



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2026 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Батсайхан  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Ugtakhbayarj@audit.gov.mn](mailto:Ugtakhbayarj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>4</b>
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....</b>	<b>4</b>
<b>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/.....</b>	<b>4</b>
<b>2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....</b>	<b>6</b>
<b>2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....</b>	<b>7</b>
<b>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....</b>	<b>7</b>
<b>/төгрөгөөр/.....</b>	<b>8</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>8</b>
<b>5.1 Төлбөрийн акт.....</b>	<b>8</b>
<b>5.2 Албан шаардлага.....</b>	<b>9</b>
<b>5.3 Зөвлөмж.....</b>	<b>9</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>0</b>

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ё.БАТБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд үндсэн хөрөнгө 72.6 сая төгрөгөөр буурсан нь элэгдэл байгуулсантай холбоотой, орон нутгаас 41.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагааг аудитад хамрагдах хугацаанд удирдлага солигдож, даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилогдсон байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

### Аудитын гол асуудал

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үр бүтээл гаргасан гэдгийг нотлох баримтгүй, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон урамшуулалд 3,028.0 мянган төгрөгийн төлбөрийн актын зөрчил илэрсэн ба тайлант онд аудитаар тухайн зөрчлийг

4826050071

давтан гаргаж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал 7,885.0 мянган төгрөгийг, нягтлан бодогчийг хэлтсийн нягтлан бодох бүртгэлийг хариуцлагатай гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсан гэх 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 3,304.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон мөн өмнөх онд гаргасан алдаа зөрчлийг давтан гаргасан тул Улсын бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын удирдлага жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 3 зорилт, 29 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 97 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,966,627.69	34,150,833.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,935,744.69	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	27,935,744.69	-
3121	Төгрөг	27,935,744.69	-
31211	Төрийн сангийн харилцах	27,935,744.69	-
33	АВЛАГА	-	15,005,744.69
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	15,005,744.69
35	БАРАА МАТЕРИАЛ	23,030,883.00	19,145,089.00
351	Түүхий эд материал	5,485,228.00	6,908,719.00
35110	Тусгай зориулалттай материал	5,485,228.00	6,908,719.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,200,005.00	2,642,650.00
354	Хангамжийн материал	14,345,650.00	9,593,720.00
35410	Бичиг хэргийн материал	7,599,100.00	5,161,500.00
35420	Аж ахуйн материал	6,226,550.00	3,912,220.00
35470	Бусад хангамжийн материал	520,000.00	520,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	157,667,638.48	101,789,466.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	157,667,638.48	101,789,466.35
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	153,286,638.48	97,932,799.63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	247,803,418.00	252,463,998.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,682,907.3)	(161,454,767.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,693,000.00	11,693,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,526,872.14)	(4,769,431.07)
393	Биет бус хөрөнгө	4,381,000.00	3,856,666.72
39301	Программ хангамж	2,123,000.00	2,123,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(1,074,333.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,808,000.00	2,808,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	208,634,266.17	135,940,300.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	15,124,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	15,124,500.00
413	Өглөг	-	15,124,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	15,124,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	208,634,266.17	120,815,800.04
51	Засгийн газрын хувь оролцоо	208,634,266.17	120,815,800.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	46,941,480.99	46,941,480.99
51101	Өмч: - төрийн	46,941,480.99	46,941,480.99
512	Хуримтлагдсан үр дүн	161,692,785.18	73,874,319.05
51210	Өмнөх үеийн үр дүн	161,692,785.18	161,692,785.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	(87,818,466.13)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	208,634,266.17	135,940,300.04

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,480,315,325.00	1,197,333,801.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,494,387.50	14,379,295.83
120	Нийтлэг татварын бус орлого	66,494,387.50	14,379,295.83
120009	Бусад орлого	-	1,400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,413,820,937.50	1,182,954,505.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,254,760,100.00	1,137,632,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,254,760,100.00	1,137,632,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,060,837.50	45,322,105.80

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,015,637.50	41,189,605.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,045,200.00	4,132,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,440,126,042.50	1,285,152,267.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,440,126,042.50	1,285,152,267.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,245,874,418.34	1,264,499,621.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926,603,829.50	1,018,686,755.00
210101	Үндсэн цалин	515,544,675.00	532,286,728.32
210102	Нэмэгдэл	281,669,614.34	271,425,182.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,774,798.16	147,997,244.00
210104	Урамшуулал	49,614,742.00	66,977,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,222,071.84	125,764,179.81
210201	Тэтгэврийн даатгал	82,842,771.84	83,899,879.81
210202	Тэтгэмжийн даатгал	8,344,800.00	10,921,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,172,400.00	5,460,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,172,400.00	5,460,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,689,700.00	20,022,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,768,400.00	9,264,400.00
210304	Байрны түрээс	5,768,400.00	9,264,400.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	22,598,134.98	23,314,600.00
210401	Бичиг хэрэг	11,174,200.00	9,579,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,396,622.00	3,989,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,326,820.00	1,658,475.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,560.00	64,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,665,932.98	3,976,635.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал актисны зардал	-	4,045,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	537,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	150,000.00	-
210604	Урсгал засвар	387,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,821,171.00	11,470,319.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,406,000.00	1,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,958,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,875,171.00	7,712,319.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,323,811.02	75,999,367.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,914,900.00	17,062,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,198,911.02	58,936,867.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194,251,624.16	20,652,645.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	192,038,966.67	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,762,766.67	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	126,076,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,212,657.49	18,400,767.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,212,657.49	18,400,767.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,251,878.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,251,878.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	40,189,282.50	(87,818,466.13)

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	40,189,282.50	(87,818,466.13)
---	-------------------------	---------------	-----------------

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	1,543,246,708.34	1,262,067,729.80
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	129,425,770.84	79,113,224.00
120	Нийтлэг татварын бус орлого	129,425,770.84	79,113,224.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,975,770.84	77,713,224.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,975,770.84	77,713,224.00
120009	Бусад орлого	27,450,000.00	1,400,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,413,820,937.50	1,182,954,505.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,254,760,100.00	1,137,632,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,254,760,100.00	1,137,632,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,060,837.50	45,322,105.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,015,637.50	41,189,605.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,045,200.00	4,132,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	1,518,916,408.34	1,290,003,474.49
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,518,916,408.34	1,290,003,474.49
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,222,189,013.34	1,176,631,859.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	951,558,116.34	1,003,562,257.40
210101	Үндсэн цалин	515,544,675.00	532,286,728.32
210102	Нэмэгдэл	286,408,699.34	271,425,185.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,990,000.00	147,997,244.00
210104	Урамшуулал	49,614,742.00	51,853,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,653,997.00	125,764,177.41
210201	Тэтгэврийн даатгал	83,274,697.00	83,899,877.41
210202	Тэтгэмжийн даатгал	8,344,800.00	10,921,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,172,400.00	5,460,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,172,400.00	5,460,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,689,700.00	20,022,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,000,000.00	9,264,400.00
210304	Байрны түрээс	6,000,000.00	9,264,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,090,000.00	17,055,525.00
210401	Бичиг хэрэг	10,260,500.00	8,218,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,396,622.00	3,989,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,380,008.00	1,658,475.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,560.00	64,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,018,310.00	3,124,190.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	165,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	165,000.00
210604	Урсгал засвар	600,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	150,000.00	-
210702	Дотоод албан томилолт	150,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,987,000.00	3,758,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,447,000.00	1,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,958,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,649,900.00	17,062,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,914,900.00	17,062,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	735,000.00	-
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	296,727,395.00	113,371,614.68

2132	Бусад урсгал шилжүүлэг	192,538,966.67	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,762,766.67	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	126,076,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,975,770.84	77,713,224.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,975,770.84	77,713,224.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,212,657.49	35,658,390.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,212,657.49	35,658,390.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,330,300.00	(27,935,744.69)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,750,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,750,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,750,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	1,750,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,750,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,580,300.00	(27,935,744.69)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,355,444.69	27,935,744.69
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,935,744.69	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	46,941,480.99	-	33,560,059.40	80,501,540.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	46,941,480.99	-	33,560,059.40	80,501,540.39
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	135,313,688.10	135,313,688.10
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,941,480.99	-	161,692,785.18	208,634,266.17
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,941,480.99	-	161,692,785.18	208,634,266.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	46,941,480.99	-	161,692,785.18	208,634,266.17
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(87,818,466.13)	(87,818,466.13)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,941,480.99	-	73,874,319.05	120,815,800.04

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
199	АРГА ХЭМЖЭЭ 80101	-	-	-
200	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,137,632,400.0	1,119,231,632.2	18,400,767.8
201	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,137,632,400.0	1,119,231,632.2	18,400,767.8
202	Бараа, үйлчилгээний зардал	1,137,632,400.0	1,119,231,632.2	18,400,767.8
203	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	975,935,400.0	967,706,499.3	8,228,900.7
204	Үндсэн цалин	564,829,800.0	532,286,728.3	32,543,071.7
205	Нэмэгдэл	276,105,600.0	235,569,427.0	40,536,173.0
206	Унаа, болон бусад нөхөн олговор	107,000,000.0	147,997,244.0	(40,997,244.0)
207	Урамшуулал	28,000,000.0	51,853,100.0	(23,853,100.0)
209	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,113,500.0	121,282,207.9	(2,168,707.9)
210	Тэтгэврийн даатгал	92,429,200.0	79,417,907.9	13,011,292.1
211	Тэтгэмжийн даатгал	10,921,100.0	10,921,100.0	-
212	ҮОМШӨ ний даатгал	5,460,500.0	5,460,500.0	-
213	Ажилгүйдлийн даатгал	5,460,500.0	5,460,500.0	-
214	Эрүүл мэндийн даатгал	4,842,200.0	20,022,200.0	(15,180,000.0)
215	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,835,900.0	9,264,400.0	(3,428,500.0)
219	Байрны түрээс	5,835,900.0	9,264,400.0	(3,428,500.0)
220	Хангамж, бараа материалын зардал	29,102,000.0	17,055,525.0	12,046,475.0
221	Бичиг хэрэг	17,755,000.0	8,218,400.0	9,536,600.0
222	Тээвэр (шатахуун)	4,007,200.0	3,989,900.0	17,300.0

223	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,850,000.0	1,658,475.0	2,191,525.0
225	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	234,400.0	64,560.0	169,840.0
226	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,255,400.0	3,124,190.0	131,210.0
232	Эд хогшил худалдан авах	582,900.0	165,000.0	417,900.0
235	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	537,900.0	165,000.0	372,900.0
236	Урсгал засвар	45,000.0	-	45,000.0
241	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,166,500.0	3,758,000.0	2,408,500.0
242	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,800,000.0	1,800,000.0	-
243	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	512,600.0	-	512,600.0
245	Тээврийн хэрэгслийн татвар	89,600.0	-	89,600.0
247	Мэдээллийн технологийн зардал	3,585,100.0	1,958,000.0	1,627,100.0
248	Газрын төлбөр	179,200.0	-	179,200.0
251	Бараа үйлчилгээний бусад зардал	896,200.0	-	896,200.0
253	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	896,200.0	-	896,200.0
393	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,137,632,400.0	1,119,231,632.2	18,400,767.8
394	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,137,632,400.0	1,119,231,632.2	18,400,767.8
395	Улсын төсвөөс санхүүжих	1,137,632,400.0	1,119,231,632.2	18,400,767.8

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,470,227.6	44,470,227.6
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	44,470,227.6	44,470,227.6
4	Бараа, үйлчилгээний зардал	44,470,227.6	44,470,227.6
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,855,758.1	35,855,758.1
7	Нэмэгдэл	35,855,758.1	35,855,758.1
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,481,969.5	4,481,969.5
12	Тэтгэврийн даатгал	4,481,969.5	4,481,969.5
53	Бараа үйлчилгээний бусад зардал	4,132,500.0	4,132,500.0
54	Бараа үйлчилгээний бусад зардал	4,132,500.0	4,132,500.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,470,227.6	44,470,227.6
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,470,227.6	44,470,227.6
123	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,337,727.6	40,337,727.6
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,132,500.0	4,132,500.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 14,688.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулсан алдаа байхгүй, 3,499.1 мянган төгрөгийн зөвлөмж, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 11,189.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг тогтоосон.

### 5.1 Төлбөрийн акт

1. Аудитаар өмч хамгаалах байнгын зөвлөлийн 5 гишүүнд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 7,885.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т (Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална), 4.1.6-д (сахилга баттай байх), 10.2-т (Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно)Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийн дагуу төсвийг хяналттай, үр ашигтай зарцуулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх

2. Нягтлан бодогчийг хэлтсийн нягтлан бодох бүртгэлийг хариуцлагатай гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсан гэх 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 3,304.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамын 1-р хавсралтын 3.3 дахь заалтанд заасан шалгуур үзүүлэл болон мөнгөн дүнгийн шалгуурыг хангаагүй үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчилд тус тус төлбөрийн акт тогтоосон.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх /улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.3 дахь “/Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна./ заалтыг тус тус зөрчсөн.

1. **Шийдвэрлэсэн нь:** Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 5 гишүүнд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 7,885.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчлийг өмч хамгаалах зөвлөлийн гишүүдээр, үр бүтээл гаргасан гэдгийг нотлох баримтгүй, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан арга хэмжээгээр давхардуулан олгосон шагнал **3,304.0** мянган төгрөгийг нягтлан бодогч Х.Гарамаар төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэх;

## 5.2 Албан шаардлага

Нягтлан бодогч Х.Гарам өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актын зөрчлийг гаргаж, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй гэх үндэслэлээр сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д (төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах), 16.5.2-т (Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.-т (хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох),

1. **Шийдвэрлэсэн нь:** Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч Х.Гарамд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, зөрчлийг таслан зогсоох;

## 5.3 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 7 шийдвэрийн 3,499.1 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн (Шилэн дансны зарчим), 4.1.1-д (мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;), 4.1.3-т (тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; ), 6 дугаар зүйлийн 6.4-т (Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:), 6.4.8-д (бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн

түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;), 7.2 -т (Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.) гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль тогтоомжид заасны дагуу шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой мэдээллийг бүрэн мэдээлж, хариу ирүүлэх.

**Зөвлөмжийн биелэлт:** Зөвлөмжийн биелэлтийг хангаж нотлох баримтыг 2026 оны 03 дугаар сарын 25 -ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100 хувийг залруулагдаагүй, алдаа эзэлж байна. Нийт илрүүлсэн 11,189.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Үүнээс 3,499.1 мянган төгрөгийн зөрчил нь нийцлийн аудитын асуудал учраас дүгнэлтэд нөлөөлөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх алдаа зөрчил илрээгүй тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогчийг хэлтсийн нягтлан бодох бүртгэлийг хариуцлагатай гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсан гэх 2 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн шагналыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.	1	3,304.0	1	3,304.0	-	-	-	-	-	-
Нягтлан бодогч Х.Гарам өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актын зөрчлийг гаргаж, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ.	1	-	-	-	1	-	-	-	-	-
Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон	1	7,885.0	1	7,885.0						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>11,189.0</b>	<b>2</b>	<b>11,189.0</b>	<b>1</b>	<b>0</b>	-	-	-	-

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 7 шийдвэрийг мэдээлээгүй.	1	3,499.1			1	3,499.1				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,499.1</b>	<b>1</b>		<b>1</b>	<b>3,499.1</b>	-	-	-	-